

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын Хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/060/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Алтай хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа  
Утас: 99998431 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг  
Утас: 99175677 Цахим хаяг: [erdenechimegd@audit.gov.mn](mailto:erdenechimegd@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Д.Цэрэнханд  
Утас: 99086371 Цахим хаяг: [tserenkhand@audit.gov.mn](mailto:tserenkhand@audit.gov.mn)  
Төгс нотолгоо аудит ХХК-ийн Ахлах аудитор: Г.Цэцэгмаа  
Утас: 99889665  
Цахим хаяг: [togsnotolgo\\_audit@gmail.com](mailto:togsnotolgo_audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.  
**Нэг. Хараат бус аудиторын санал, дүгнэлт:**



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 02.16 № 57

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЕСӨНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН ХОЁРДУГААР  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Э.ТЭРБИШ  
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын ерөнхий боловсролын Хоёрдугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд улсын төсвөөс авах санхүүжилт 340,931.8 мянган төгрөгөөр өссөн, орон нутгийн төсвийн санхүүжилт 45,126.4 мянган төгрөгөөр буурсан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд хандив тусламжаар 24,240.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 5,949.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 17,035.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, төсвийн хөрөнгөөр 21,600.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 7,935.0 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг бэлтгэн данс бүртгэлд тусгасан байна.

**Бусад асуудал**

Тайлант онд 1 хөтөлбөр, 7 зорилт, 60 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 52 арга хэмжээг бүрэн, 8 арга хэмжээг дутуу, нийт дүнгээр 96.0 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд Боловсролын газраас 87.2 хувиар үнэлсэн байна.

822505000156

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

## ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>289,905,124.06</b>	<b>228,939,676.40</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	108,150,929.55	40,337,648.19
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	108,150,929.55	40,337,648.19
3121	Төгрөг	108,150,929.55	40,337,648.19
31211	Төрийн сангийн харилцах	108,150,929.55	40,337,648.19
35	БАРАА МАТЕРИАЛ	181,754,194.51	188,602,028.21
351	Түүхий эд материал	119,793,938.92	120,827,438.92
35110	Тусгай зориулалттай материал	119,793,938.92	120,827,438.92
354	Хангамжийн материал	61,960,255.59	67,774,589.29
35420	Аж ахуйн материал	2,263,000.00	1,371,000.00
35470	Бусад хангамжийн материал	59,697,255.59	66,403,589.29
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,548,340,651.36</b>	<b>3,444,088,256.35</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,548,340,651.36	3,444,088,256.35
392	Биет хөрөнгө	3,365,441,841.44	3,263,863,216.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,216,275,424.36	3,240,515,424.36
39202	Хуримтлагдсан элэгдэл	(356,867,598.69)	(445,993,116.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	469,835,148.00	476,877,143.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	(183,061,909.58)	(204,798,764.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	255,197,640.81	205,251,886.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	(120,936,863.46)	(92,989,357.92)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	85,000,000.00	85,000,000.00
393	Биет бус хөрөнгө	182,898,809.92	180,225,039.88
39301	Програм хангамж	17,122,600.00	10,687,600.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(10,203,790.08)	(6,442,560.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	175,980,000.00	175,980,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,838,245,775.42</b>	<b>3,673,027,932.75</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,075,100.00</b>	<b>54,425,796.08</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,075,100.00</b>	<b>54,425,796.08</b>
413	Өглөг	6,075,100.00	54,425,796.08
4136	Бусад өглөг	6,075,100.00	54,425,796.08
41361	Байгууллагад төлөх өглөг	6,075,100.00	54,425,796.08
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,832,170,675.42</b>	<b>3,618,602,136.67</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	3,832,170,675.42	3,618,602,136.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,221,963,896.63	1,221,963,896.63
51101	Өмч: - төрийн	1,221,963,896.63	1,221,963,896.63
512	Хуримтлагдсан үр дүн	1,812,546,529.91	1,598,977,991.16
51210	Өмнөх үеийн үр дүн	1,876,706,250.59	1,812,546,529.91
51220	Тайлант үеийн үр дүн	(64,159,720.68)	(213,568,538.75)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	797,660,248.88	797,660,248.88
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,838,245,775.42</b>	<b>3,673,027,932.75</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,008,976,032.30</b>	<b>3,256,548,320.41</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>86,471,432.30</b>	<b>126,560,820.41</b>
120	Нийтлэг татварын бус орлого	86,471,432.30	126,560,820.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	31,175,100.00	15,575,478.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,035,300.00	7,285,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,044,800.00	8,290,378.00

Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын Хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	48,008,119.00	101,308,008.71
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,288,213.30	9,677,333.70
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,922,504,600.00</b>	<b>3,129,987,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,401,387,600.00</b>	<b>2,742,319,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,401,387,600.00	2,742,319,400.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>521,117,000.00</b>	<b>387,668,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	521,117,000.00	387,668,100.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,066,827,160.84</b>	<b>3,441,178,700.45</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,066,827,160.84</b>	<b>3,441,178,700.45</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,979,069,352.67</b>	<b>3,303,686,200.45</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,966,766,442.00</b>	<b>2,252,886,561.59</b>
210101	Үндсэн цалин	1,285,948,361.85	1,344,191,305.00
210102	Нэмэгдэл	596,916,110.15	752,697,542.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	68,320,024.00
210104	Урамшуулал	83,901,970.00	87,677,690.59
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>247,227,490.00</b>	<b>282,390,763.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	168,745,950.00	192,675,704.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,852,465.00	22,667,730.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,856,933.00	11,288,325.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,754,429.00	11,151,801.00
210205	Эрүүл мэндийн даатгал	39,017,713.00	44,607,203.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>431,581,507.25</b>	<b>430,093,896.08</b>
210301	Гэрэл, цахилгаан	12,261,980.37	11,566,345.20
210302	Түлш, халаалт	389,445,814.88	389,445,838.88
210303	Цэвэр, бохир ус	29,873,712.00	29,081,712.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>19,800,000.00</b>	<b>12,000,000.00</b>
210604	Урсгал засвар	19,800,000.00	12,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>41,047,563.89</b>	<b>46,667,672.77</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,436,100.00	7,284,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	37,611,463.89	39,382,772.77
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>272,646,349.53</b>	<b>279,647,307.01</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,801,582.12	59,519,912.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,900,150.00	13,970,150.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	199,944,617.41	206,157,245.01
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>87,757,808.17</b>	<b>137,492,500.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>86,293,500.00</b>	<b>137,492,500.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	86,293,500.00	137,492,500.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(57,851,128.54)</b>	<b>(184,630,380.04)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,308,592.14</b>	<b>28,938,158.71</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,308,592.14	28,938,158.71
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(6,308,592.14)</b>	<b>(28,938,158.71)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(64,159,720.68)</b>	<b>(213,568,538.75)</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,951,584,700.00</b>	<b>3,145,562,978.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>29,080,100.00</b>	<b>15,575,478.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>29,080,100.00</b>	<b>15,575,478.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,080,100.00	15,575,478.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,035,300.00	7,285,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,044,800.00	8,290,378.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,922,504,600.00</b>	<b>3,129,987,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,401,387,600.00</b>	<b>2,742,319,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,401,387,600.00	2,742,319,400.00

Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын Хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	521,117,000.00	387,668,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	521,117,000.00	387,668,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,962,478,611.53</b>	<b>3,183,841,259.36</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,962,478,611.53</b>	<b>3,183,841,259.36</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,874,720,803.36</b>	<b>3,046,348,759.36</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,966,766,442.00	2,252,886,561.59
210101	Үндсэн цалин	1,285,948,361.85	1,344,191,305.00
210102	Нэмэгдэл	596,916,110.15	752,697,542.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	68,320,024.00
210104	Урамшуулал	83,901,970.00	87,677,690.59
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>247,227,490.00</b>	<b>282,390,763.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	168,745,950.00	192,675,704.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,852,465.00	22,667,730.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,856,933.00	11,288,325.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,754,429.00	11,151,801.00
210205	Эрүүл мэндийн даатгал	39,017,713.00	44,607,203.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>468,852,691.83</b>	<b>375,668,100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	12,261,980.37	11,566,345.20
210302	Түлш, халаалт	426,716,999.46	335,020,042.80
210303	Цэвэр, бохир ус	29,873,712.00	29,081,712.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>19,800,000.00</b>	<b>12,000,000.00</b>
210604	Урсгал засвар	19,800,000.00	12,000,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>54,326,745.89</b>	<b>46,667,672.77</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,035,300.00	7,284,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	40,291,445.89	39,382,772.77
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>117,747,433.64</b>	<b>76,735,662.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	96,761,283.64	62,749,512.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,986,150.00	13,986,150.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>87,757,808.17</b>	<b>137,492,500.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>86,293,500.00</b>	<b>137,492,500.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	86,293,500.00	137,492,500.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(10,893,911.53)</b>	<b>(38,278,281.36)</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>33,736,000.00</b>	<b>29,535,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>33,736,000.00</b>	<b>29,535,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>33,736,000.00</b>	<b>29,535,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,736,000.00	29,535,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(33,736,000.00)</b>	<b>(29,535,000.00)</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(44,629,911.53)</b>	<b>(67,813,281.36)</b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>152,780,841.08</b>	<b>108,150,929.55</b>
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>108,150,929.55</b>	<b>40,337,648.19</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,221,963,896.63	797,660,248.88	1,876,706,250.59	3,896,330,396.10
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,221,963,896.63	797,660,248.88	1,876,706,250.59	3,896,330,396.10
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(64,159,720.68)	(64,159,720.68)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,221,963,896.63	797,660,248.88	1,812,546,529.91	3,832,170,675.42

**Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын Хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,221,963,896.63	797,660,248.88	1,812,546,529.91	3,832,170,675.42
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,221,963,896.63	797,660,248.88	1,812,546,529.91	3,832,170,675.42
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(213,568,538.75)	(213,568,538.75)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,221,963,896.63	797,660,248.88	1,598,977,991.16	3,618,602,136.67

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)**

	ҮЗҮҮЛЭЛТ	БАТАЛСАН	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,264,788,578.00</b>	<b>3,213,376,259.36</b>	<b>51,412,318.64</b>	<b>98.4</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,264,788,578.00</b>	<b>3,213,376,259.36</b>	<b>51,412,318.64</b>	<b>98.4</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,126,288,178.00</b>	<b>3,075,883,759.36</b>	<b>50,404,418.64</b>	<b>98.4</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,266,827,500.00</b>	<b>2,252,886,561.59</b>	<b>13,940,938.41</b>	<b>99.4</b>
210101	Үндсэн цалин	1,443,365,300.00	1,344,191,305.00	99,173,995.00	93.1
210102	Нэмэгдэл	757,894,600.00	752,697,542.00	5,197,058.00	99.3
210104	Урамшуулал	65,567,600.00	87,677,690.59	(22,110,090.59)	133.7
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>288,353,400.00</b>	<b>282,390,763.00</b>	<b>5,962,637.00</b>	<b>97.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	196,080,300.00	192,675,704.00	3,404,596.00	98.3
210202	Тэтгэмжийн даатгал	23,068,300.00	22,667,730.00	400,570.00	98.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,534,100.00	11,288,325.00	245,775.00	97.9
210204	Ажилгүйдлийн даатгал	11,534,100.00	11,151,801.00	382,299.00	96.7
210205	Эрүүл мэндийн даатгал	46,136,600.00	44,607,203.00	1,529,397.00	96.7
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>375,668,100.00</b>	<b>375,668,100.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	16,200,000.00	11,566,345.20	4,633,654.80	71.4
210302	Түлш, халаалт	324,368,100.00	335,020,042.80	(10,651,942.80)	103.3
210303	Цэвэр, бохир ус	35,100,000.00	29,081,712.00	6,018,288.00	82.9
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,000,000.00</b>	<b>12,000,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	12,000,000.00	12,000,000.00	-	100.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>48,670,300.00</b>	<b>46,667,672.77</b>	<b>2,002,627.23</b>	<b>95.9</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,284,900.00	7,284,900.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	41,385,400.00	39,382,772.77	2,002,627.23	95.2
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>134,768,878.00</b>	<b>106,270,662.00</b>	<b>28,498,216.00</b>	<b>78.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	120,782,378.00	92,284,512.00	28,497,866.00	76.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,986,500.00	13,986,150.00	350.00	100.0
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>138,500,400.00</b>	<b>137,492,500.00</b>	<b>1,007,900.00</b>	<b>99.3</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>138,500,400.00</b>	<b>137,492,500.00</b>	<b>1,007,900.00</b>	<b>99.3</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	138,500,400.00	137,492,500.00	1,007,900.00	99.3
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,264,788,578.00</b>	<b>3,213,376,259.36</b>	<b>51,412,318.64</b>	<b>96.3</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,742,319,400.00</b>	<b>2,742,319,400.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>

**Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын Хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

131001	Улсын төсвөөс санхүүжих	2,742,319,400.00	2,742,319,400.00	-	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	387,668,100.00	387,668,100.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	387,668,100.00	387,668,100.00	-	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>134,801,078.00</b>	<b>83,388,759.36</b>	<b>51,412,318.64</b>	11.6
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	16,084,878.00	7,285,100.00	8,799,778.00	45.3
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	15,690,400.00	8,290,378.00	7,400,022.00	52.8
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	103,025,800.00	67,813,281.36	35,212,518.64	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		108,150,929.55		
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		40,337,648.19		

### **ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар залруулга гараагүй.

Залруулагдаагүй нийт 12,024.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 12,024.0 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>1</sup> илэрсэнд 3 зөвлөмж хүргүүлсэн.

#### **3.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **Нэг. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/238 А/340 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан цэцэрлэг ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хамруулах нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалтад заагаагүй шинжилгээнд албан хаагчдыг хамруулж, 2,820.0 мянган төгрөгийн зардлыг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"-тай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, тайлагнаж байх.

##### **Хоёр. Цалингийн зардалтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Байгууллагын батлагдсан орон тооны бүтцэд байхгүй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтанд 2,968.0 мянган төгрөгийн, хүний нөөц хариуцсан албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж 6,236.0 мянган төгрөгийн нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-т "батлагдсан төсөв,

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн төсөл болон ажилтны ажил үүргийн хуваарьт тусган ажил хавсарсны нэмэгдлийг олгож байх.

#### **Гурав. Баталсан төсөвтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцож цалингийн зардлаас 68,320.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид унаа хоолны хөнгөлөлтийг төсвийн төсөлд тусган, баталсан зардлын хүрээнд зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН зөрчлийн НЭГТГЭЛ**

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1		3	4	5	6	7	8	9	10	11	12	
Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын Хоёрдугаар сургууль	Боловсрол шинжлэх ухааны сайд. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/238 А/340 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хамруулах нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалтад заагаагүй шинжилгээнд албан хаагчдыг хамруулж, 2,820.0 мянган төгрөгийн зардлыг үр ашиггүй зарцуулсан.	1	2,820.0	-	-	-	-	1	2,820.0	-	-	
	Байгууллагын батлагдсан орон тооны бүтцэд байхгүй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан 2,968.0 мянган төгрөгийн, хүний нөөц хариуцсан албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж 6,236.0 мянган төгрөгийн, нэмэгдэл олгосон.	1	9,204.0	-	-	-	-	-	1	9,204.0	-	-
	Батлагдсан төсөвт хоол, унааны хөнгөлөлт тусгагдаагүй байхад Боловсролын сайдын 2025 оны "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн өдрийн 5.0 мянган төгрөгөөр тооцож цалингийн зардлаас 68,320.0 мянган төгрөгийг олгосон.	1	-	-	-	-	-	-	1	-	-	-
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>12,024.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>12,024.0</b>	<b>-</b>	<b>-</b>	

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			